



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/43

Хэрлэн сум

Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сарын шинийн нэгнийг тохиолдуулан 90 ба түүнээс дээш настай ахмадуудад хүндэтгэл үзүүлсүгэй.
2. Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 5,354,000 (таван сая гурван зуун тавин дөрвөн мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
3. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
4. Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбазатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010170

Аймгийн Засаг даргын 2022 оны
...01 дүгээр сарын 25 өдрийн ... АЖТ
дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Гарын бэлэг/ чацаргана, чихэр, печень/	98	46,000	4,508,000
2	Бэлэг хайрцаг	80	8,700	696,000
2	Тээврийн зардал		150,000	150,000
	Дүн			5,354,000